

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/245/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

"Голден пэйж Аудит" ХХК

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

**ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.МӨНХ-УЧРАЛ ТАНАА**

2024.02.25 № 01/81
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам баталсан. Уг журмыг үндэслэн Татварын ерөнхий газрын даргын тушаалаар татварын жинхэнэ зөвлөх, татварын итгэмжит зөвлөх, татварын зөвлөх гэсэн цол олгон, цолны нэмэгдэл үр дүнгийн шагнал 1албан хаагчид 7,280.0 мянган төгрөг олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөр 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 94,8 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

019000092

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	104,335,859.91	112,726,389.50
35	БАРАА МАТЕРИАЛ	104,335,859.91	112,726,389.50
351	Түүхий эд материал	442,970.00	399,080.00
35130	Эм боох материал	442,970.00	399,080.00
354	Хангамжийн материал	103,892,889.91	112,327,309.50
35410	Бичиг хэргийн материал	15,091,800.21	13,728,274.66
35420	Аж ахуйн материал	83,214,489.64	91,591,334.84
35430	Сэлбэг хэрэгсэл	1,920,000.00	1,920,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.06	1,457,000.00
35450	Барилгын засварын материал	23,500.00	3,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,643,100.00	3,627,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	412,917,390.65	391,809,933.49
39	Үндсэн хөрөнгө	412,917,390.65	391,809,933.49
392	Биет хөрөнгө	397,017,390.65	375,909,933.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	280,441,881.76	280,441,881.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,356,365.09)	(36,447,247.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,000,000.00	118,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,835,839.33)	(35,335,839.33)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	321,891,351.67	283,308,233.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(279,727,956.06)	(252,885,033.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,476,684.64	35,789,782.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,219,183.94)	(18,808,661.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,250,000.00	20,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,250,000.00)	(20,250,000.00)
39217	Ном	1,346,817.00	1,346,817.00
393	Биет бус хөрөнгө	15,900,000.00	15,900,000.00
39301	Програм хангамж	830,550.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(830,550.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	15,900,000.00	15,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	517,253,250.56	504,536,322.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	517,253,250.56	504,536,322.99
51	Засгийн газрын хувь оролцоо	517,253,250.56	504,536,322.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,465,028.90	346,465,028.90
51101	Өмч: - төрийн	346,465,028.90	346,465,028.90
512	Хуримтлагдсан үр дүн	117,585,700.78	104,868,773.21
51210	Өмнөх үеийн үр дүн	235,538,525.02	117,646,420.72
51220	Тайлант үеийн үр дүн	(117,952,824.24)	(12,777,647.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,202,520.88	53,202,520.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	517,253,250.56	504,536,322.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,022,579,579.38	1,740,994,109.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,803,679.38	9,983,143.20
120	Нийтлэг татварын бус орлого	8,803,679.38	9,983,143.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,803,679.38	9,983,143.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,803,679.38	9,983,143.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,775,900.00	1,731,010,966.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,013,775,900.00	1,645,876,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,775,900.00	1,645,876,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	85,134,766.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	85,134,766.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,140,532,403.62	1,753,771,756.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,140,532,403.62	1,753,771,756.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	893,637,000.68	1,584,499,644.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,664,117.57	1,208,074,250.65
210101	Үндсэн цалин	359,561,796.75	586,556,010.97
210102	Нэмэгдэл	74,660,729.63	289,091,980.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,493,477.27	56,053,292.23
210104	Урамшуулал	55,948,113.92	276,372,967.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,742,959.15	154,049,209.28
210201	Тэтгэврийн даатгал	46,901,052.14	105,371,888.88
210202	Тэтгэмжийн даатгал	5,469,926.70	12,396,707.24
210203	ҮОМШ өвчний даатгал	4,365,861.30	9,800,001.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,091,465.40	2,417,561.89
210205	Эрүүл мэндийн даатгал	10,914,653.61	24,063,049.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,665,412.26	54,561,475.27
210301	Гэрэл цахилгаан	5,139,712.26	6,596,937.78
210302	Түлш, халаалт	38,125,700.00	45,356,751.49
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,607,786.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,710,167.68	18,068,024.01
210401	Бичиг хэрэг	5,671,630.00	4,183,755.55
210402	Тээвэр, шатахуун	3,854,515.00	5,806,200.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,922,337.10	3,791,841.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,021,685.58	4,046,227.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	799,851.00	6,705,200.00
210604	Урсгал засвар	799,851.00	6,705,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,294,800.00	1,308,000.00
210702	Дотоод албан томилолт	1,294,800.00	1,308,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,995,831.98	87,418,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,653,686.98	86,399,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,920.00	140,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	39,643.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,763,861.04	54,314,997.16

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,989,041.80	20,682,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,075,640.00	4,087,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	119,699,179.24	29,545,257.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,895,402.94	169,272,112.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,527,526.00	2,730,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,527,526.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,730,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	196,367,876.94	166,542,112.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,367,876.94	166,542,112.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(117,952,824.24)	(12,777,647.51)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(117,952,824.24)	(12,777,647.51)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,013,775,900.00	1,731,010,966.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,775,900.00	1,731,010,966.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,013,775,900.00	1,645,876,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,775,900.00	1,645,876,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	85,134,766.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	85,134,766.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,013,775,900.00	1,731,010,966.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,013,775,900.00	1,731,010,966.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,880,497.06	1,561,738,853.66
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	546,664,117.57	1,208,074,250.65
210101	Үндсэн цалин	366,403,334.67	585,897,365.10
210102	Нэмэгдэл	68,998,287.75	289,750,626.02
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	56,373,477.27	56,053,292.23
210104	Урамшуулал	54,889,017.88	276,372,967.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,742,959.15	154,049,209.28
210201	Тэтгэврийн даатгал	46,723,604.14	105,371,888.88
210202	Тэтгэмжийн даатгал	5,542,638.75	12,396,707.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,393,790.96	9,800,001.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,098,447.82	2,417,561.89
210205	Эрүүл мэндийн даатгал	10,984,477.48	24,063,049.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,665,412.26	54,561,475.27
210301	Гэрэл, цахилгаан	5,139,712.26	6,596,937.78
210302	Түлш, халаалт	38,125,700.00	45,356,751.49
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,607,786.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,231,736.10	14,942,190.46
210401	Бичиг хэрэг	3,955,450.00	4,038,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,933,800.00	3,076,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,922,337.10	3,791,841.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,180,149.00	3,795,299.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,220,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	2,220,000.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,294,800.00	1,308,000.00
210702	Дотоод албан томилолт	1,294,800.00	1,308,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,995,831.98	92,115,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,653,686.98	91,096,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	96,525.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,920.00	140,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	39,643.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,065,640.00	29,688,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	23,582,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,065,640.00	6,106,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,895,402.94	169,272,112.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,527,526.00	2,730,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,527,526.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,730,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	196,367,876.94	166,542,112.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,367,876.94	166,542,112.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгөмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	635,206,074.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	635,206,074.80
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(117,952,824.24)	(117,952,824.24)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	117,585,700.78	517,253,250.56
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	117,585,700.78	517,253,250.56
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,777,647.51)	(12,777,647.51)
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	104,868,773.21	504,536,322.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,645,876,200.00	1,645,876,200.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,645,876,200.00	1,645,876,200.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,643,126,200.00	1,477,259,981.33	165,866,218.67	89.91
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,297,617,600.00	1,153,935,780.42	143,681,819.58	88.93
21010100	Үндсэн цалин	602,281,100.00	585,897,365.10	16,383,734.90	97.28
21010200	Нэмэгдэл	284,923,500.00	235,612,155.79	49,311,344.21	82.69
21010300	Унаа хоолны Хөнгөлөлт	74,311,300.00	56,053,292.23	18,258,007.77	75.43
21010400	Урамшуулал	336,101,700.00	276,372,967.30	59,728,732.70	82.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,202,200.00	147,291,027.18	14,911,172.82	90.81
21020100	Тэтгэврийн даатгал	110,297,500.00	100,757,556.88	9,539,943.12	91.35
21020200	Тэтгэмжийн даатгал	12,976,100.00	11,853,830.24	1,122,269.76	91.35
21020300	ҮОМШӨ-ний даатгал	10,380,900.00	9,271,863.98	1,109,036.02	89.32
21020400	Ажилгүйдлийн даатгал	2,595,300.00	2,309,797.89	285,502.11	89.00
21020500	Эрүүл мэндийн даатгал	25,952,400.00	23,097,978.19	2,854,421.81	89.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,649,200.00	54,561,475.27	1,087,724.73	98.05
21030100	Гэрэл, цахилгаан	7,589,900.00	6,596,937.78	992,962.22	86.92
21030200	Түлш, халаалт	45,356,900.00	45,356,751.49	148.51	100.00
21030300	Цэвэр, бохир ус	2,702,400.00	2,607,786.00	94,614.00	96.50
2104	Хангамж, бараа материалын зардал	17,380,000.00	14,942,190.46	2,437,809.54	85.97
21040100	Бичиг хэрэг	4,040,000.00	4,038,850.00	1,150.00	99.97
21040200	Тээвэр, шатахуун	4,200,000.00	3,076,200.00	1,123,800.00	73.24
21040300	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900,000.00	3,791,841.46	108,158.54	97.23
21040500	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	-	100.00
21040600	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	3,795,299.00	1,204,701.00	75.91

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
21060400	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,750,000.00	1,308,000.00	2,442,000.00	34.88
21070200	Дотоод албан томилолт	3,750,000.00	1,308,000.00	2,442,000.00	34.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,527,200.00	92,115,488.00	411,712.00	99.56
21080100	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,097,000.00	91,096,900.00	100.00	100.00
21080200	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.00
21080300	Даатгалын үйлчилгээ	500,000.00	96,525.00	403,475.00	19.31
21080400	Тээврийн хэрэгслийн татвар	140,500.00	140,420.00	80.00	99.94
21080500	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	-	100.00
21080700	Газрын төлбөр	47,700.00	39,643.00	8,057.00	83.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	6,106,020.00	893,980.00	87.23
21090200	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	7,000,000.00	6,106,020.00	893,980.00	87.23
21110100	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,750,000.00	2,730,000.00	20,000.00	99.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,750,000.00	2,730,000.00	20,000.00	99.27
21320900	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,730,000.00	20,000.00	99.27
26030100	Төвлөрүүлэг шилжүүлэг		165,886,218.67		
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,645,876,200.00	1,645,876,200.00	-	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,645,876,200.00	1,645,876,200.00	-	100.00
13100100	Улсын төсвөөс санхүүжих	1,645,876,200.00	1,645,876,200.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	Ажиллагсдын тоо	52	40	12.00	76.92
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	47	35	12.00	74.47
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.00

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,716.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	104,335.9	112,726.4	8,390.5
Үндсэн хөрөнгө	412,917.4	391,809.9	(21,107.5)
Нийт хөрөнгө	517,253.2	504,536.3	(12,716.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	346,465.0	346,465.0	-
Хуримтлагдсан үр дүн	117,585.7	104,868.8	(12,716.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,202.5	53,202.5	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	517,253.2	504,536.3	(12,716.9)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,390.5 мянган төгрөгөөр өссөн нь татварын ерөнхий газраас ирсэн бараа материалыг орлогодсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 21,107.5 мянган төгрөгөөр буурсан нь Татварын ерөнхий газраас 8,437.8 мянган төгрөгийн проектор ирснийг орлогдож, Төрийн өмчийн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 26 дугаар тогтоол 46,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий Ниссан Навара суудлын автомашиныг Ховд аймгийн Ховд Шим Ус ОНӨХХТҮГ-руу балансаас баланс руу шилжүүлсэн, Төрийн өмчийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 685 дугаар тогтоолоор 65,538.4 мянган төгрөгийн ашиглах боломжгүй хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Татварын хэлтсийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,223,888.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлыг тус тус өсгөж 1,645,876.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Татварын хэлтсийн төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс цалин нэмэгдсэн, 2023 оны 4 дүгээр сарын 01-ны өдрөөс халаалтын төлбөр нэмэгдсэнтэй холбоотой өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 421,988.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,645,876.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 85,134.8 мянган төгрөгийг олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,643,876.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 1,479,989.9 мянган төгрөг буюу 89,9 хувьтай зарцуулж, 165,886.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь гэрэл цахилгаан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	1,556,726.2	1,390,860.1	165,866.1	89.3
2	80205 Мэдээлэл сурталчилгааны зардал	1,500.0	1,500.0	-	100.0
3	80219 Харуул хамгаалалтын зардал	28,800.0	28,800.0	-	100.0
4	80220 Холбооны суваг ашигласны хөлс	56,100.0	56,099.9	0.1	100.0
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,750.0	2,730.0	20.0	99.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Татварын хэлтэс нь төсвийн орлогын бүрдүүлэх, татварын хувь тогтоомжийг татвар төлөгчдөд сурталчлах, татварын хуулийн хэрэгжилтэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт тавих чиг үүрэгтэйгээр, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгоор ажилласан байна.

Төв аймгийн Татварын хэлтэс нь тайлант онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
- Татвар төлөгчийг бүртгэх, тайлан хүлээн авах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа хийх үйлчилгээг татвар төлөгчийн ангилалд нийцүүлэн чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх
- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, улсын хэмжээнд нэг мөр мөрдүүлэх
- Татвар төлөгчийн эрсдэлийг бүртгэх, үнэлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, тандалт судалгаа, шинжилгээ хийх
- Татвар төлөгчийн ангилал, эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах, татварын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- Татвар төлөх, татварын өр хураах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих
- Төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх
- Дотоод ажил

Татварын хэлтэс нь 3 шатны орлогын бүрдүүлэлтийн төлөвлөгөөг нийт 128,3 хувиар, үүнээс сум орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 117 хувь, аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 214.7 хувь, улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 108.1 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Татварын хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль нэмэлт өөрчлөлт
- Нэмүү өртгийн албан татвар нэмэлт өөрчлөлт
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нэмэлт өөрчлөлт
- Хувь хүний орлогын албан татвар нэмэлт өөрчлөлт
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан тавар нэмэлт өөрчлөлт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвөөс 61,062.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/321 тоот захирамжаар 4,072.0 мянган төгрөг, А/702 тоот захирамжаар 20,000.0 мянган төгрөгийн халаалтын зардлын орлого бүрдүүлж, цалингийн зардалд 60,896.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 23,582.2 мянган төгрөг зарцуулж 655.9 мянган төгрөгийг улсын төсөв төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оны эхэнд 5,640.0 мянган төгрөгөөр батлуулсан, нэмэлт өөрчлөлтөөр 128,589.2 мянган төгрөг болгож өөрчилсөн байна. Гүйцэтгэлээр 128,589.2 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, өөрийн дотоодын харилцагч нараас худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,022,579.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,338.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 155 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 3,335.3 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв орхигдуулсан зүйлгүй оруулдаг байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 103,491.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2 зөвлөмжийн хэрэгжилт дутуу хэрэгжсэн байх тул гүйцэтгэлээр давтан шалгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,052.6 мянган төгрөгийн 6 зөрчил илэрч 3 албан шаардлага өгсөн байна. Биелэлт 100 хувьтай хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	9,052.6	3	9,052.6	100
Нийт дүн	3	9,052.6	3	9,052.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал нь Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам нь Сангийн сайдын тушаалаар олгогддог, <https://legalinfo.mn/mn> эрхзүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлгүй, татварын ерөнхий газрын даргын цол олгодог тушаал шийдвэр нь эрхзүйд нийцсэн хүчин төгөлдөр болсон эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,076.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 32,076.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын талаар холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд 32,076.6 мянган төгрөгийн зөрүүтэй гүйлгээ гарсан байгаа нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ."* гэсэн заалтуудтай зөрчилдөж байна

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд 32,076.6 мянган төгрөгийн зөрүүтэй гүйлгээ гарсан байгаа	1	32,076.6					1	32,076.6				
Дүн	1	32,076.6					1	32,076.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 155 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 3,335.3 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.	1	3,335.3					1	3,335.3
Дүн	1						1	3,335.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	3,335.3					1	3,335.3